



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 05 өдөр

Дугаар 01503

Хэрлэн сум

Үнэ бууруулж худалдах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 49 дүгээр тогтоолоор батлагдсан “Дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээ”-ний 2.5, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны хорин нэгдүгээр хуралдааны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. “Өндөрхаан сүү” ОНӨААТҮГ-ын сүүний үйлдвэрийн 157,880,000 төгрөгийн балансын үнэтэй 3,060,000 төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 154,820,00 төгрөгийн үлдэх өртөгтэй тоног төхөөрөмжийг анхны дуудлага худалдааны үнэ 154,820,000 төгрөгөөс 50 хувиар үнэ бууруулж 77,410,000 төгрөгөөр худалдах, Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын Засаг даргын тамгын газрын 49,500,000 төгрөгийн балансын үнэтэй, 18,150,000 төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 31,350,000 төгрөгийн үлдэх өртөгтэй автомашиныг анхны дуудлага худалдааны үнэ 31,350,000 төгрөгөөс 50 хувиар үнэ бууруулж 15,675,000 төгрөгөөр худалдахаар баталсугай.

2. Худалдах эд хөрөнгийн нээлттэй дуудлагын худалдааг зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч:

Г.Лхагвахатан

Орон нутгийн өмчийн газрын дарга

Хөтлөгч:

Б.Должинсүрэн

Орон нутгийн өмчийн газрын  
мэргэжилтэн

Тэмдэглэл

хөтлөгч:

Л.Отгончимэг

Орон нутгийн өмчийн газрын хуулийн  
зөвлөх

3. Худалдах эд хөрөнгийн нээлттэй дуудлагын худалдааг 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 11 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын 106 тоот өрөөнд зохион байгуулсугай.

2.

4.Эд хөрөнгийн дуудлага худалдаа хийх ажлыг хууль тогтоомжинд нийцүүлэн зохион байгуулахыг Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга (Г.Лхагвахатан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ